

**АРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ  
02 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

**Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл**

Ковид-19 халдварын цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан аймгийн онцгой комисс 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдөр хуралдаж дараах шийдвэрүүдийг гаргалаа. Үүнд

1. Засгийн газрын шийдвэрээр ногоон бүс дэх аймаг, сумдын хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг 2021 оны 03 дугаар сарын 01-ны өдрөөс эхлүүлэхтэй холбогдуулан бэлтгэл ажлыг хангах, халдвар хамгааллын дэглэм мөрдөж ажиллах

2. Аймгийн хэмжээнд үйл ажиллагааг нь хязгаарласан бүх төрлийн танхимын болон үйлдвэрлэлийн сургалт, хурал цуглаан, хүлээн авалт, спортын клуб, биллиард, гандан, сүм хийд, театр, соёлын төв, кино театрын үзвэр, үйлчилгээ, гоо сайхан, бариа засал, амралт жуулчны баазын үйл ажиллагааг 03 дугаар сарын 01-ны өдрөөс Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 18 дугаар тушаалаар баталсан коронавируст халдвараас сэргийлэх тусгай шаардлагын дагуу үе шаттайгаар нээж ажиллуулах.

3. Биеийн тамир спортын газрын заал, МУБИС-ийн Архангай аймаг дахь Багшийн сургуулийн спорт заалыг халдваргүйжүүлэлт хийж, 18-аас дээш насны иргэдийг нэг удаа 12-оос дээшгүй хүний тоотой, 1 цаг 30 минутын хугацаанд, өдрийн 09:00-20:00 цагийн хугацаанд халдвар хамгааллын дэглэмийн дагуу нээж ажиллуулах.

4. Ерөнхий боловсролын сургуулийн спорт зааланд хичээл сургалт явуулахгүй байх, иргэдэд үйлчлэхийг хориглох.

5. Мөн диско баар, караоке, урлаг, спортын уралдаан тэмцээн, цахим тоглоомын газар, өргөтгөсөн үзэсгэлэн худалдааны үйл ажиллагааг хориглох

6. Улаанбаатар хотоос гарах орох хөдөлгөөнийг 2021 оны 03 дугаар сарын 01-ны өдрөөс нээх болсонтой холбогдуулан Архангай аймагт ирэх иргэдийг бүртгэлжүүлж, PCR шинжилгээг үндэслэн нэвтрүүлэх, ирсэн иргэд гэрийн ажиглалтад 7 хоног өөрсдийгөө тусгаарлах, аймаг /70332772/ сумын Онцгой комиссын Шуурхай штабын утсанд заавал бүртгүүлэх зэрэг шаардлагуудыг тавьж байна.

7. Хот хооронд зорчих хөдөлгөөн, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг нээж ажиллуулсан, коронавирусын халдварын тархалт буураагүй байгаа тул онцын шаардлагагүй бол халдварын голомттой газар болон олон хүн төвлөрсөн газраар явахгүй байх, хүн хоорондын зай барих, амны хаалт тогтмол зүүхийг нийт иргэдэд анхааруулж байна.

Засгийн газрын тогтоолын дагуу Цагаан сарын баярыг нийтээр тэмдэглэхгүй байх, /ковид-19/ цар тахлын халдвар нэмэгдэж байгаатай холбогдуулан иргэдийг халдвараас хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Засаг даргын захирамжаар аймаг, сум, хот хооронд зорчих иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2021.01.29-ний өдрийн 09:00 цагаас 2021.02.23-ны өдрийг хүртэл хориглож аймаг, сумын төвөөс гарах, орох хөдөлгөөнд хязгаарлалт тогтоож байнгын 55 постод 89 алба хаагч, хөдөлгөөнт 18 постод 74 алба хаагч, үүнээс Цагдаагийн газрын 37, Онцгой байдлын газрын 39, бусад төрийн байгууллагын 87 алба хаагч нийт 163 алба хаагч үүрэг гүйцэтгэсэн байна

2021 оны 2-р сарын 25-ны өдөр аймгийн удирдах ажилтны ээлжит шуурхай зөвлөгөөн болж, зөвлөгөөнийг аймгийн Засаг даргын орлогч В.Мөнхбат нээж, аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газрын дарга нар мэдээлэл хийв.

Мөн энэ үеэр аймгийн Засаг даргын орлогч агентлаг, байгууллагын дарга нарт 12 төрлийн үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг удирдах ажилтнуудад үүрэг болголоо.

Мөн өдөр аймгийн удирдлагууд, мэргэжлийн байгууллагын дарга нар сумдын Засаг дарга болон байгууллагын дарга нартай ээлжит онлайн хурлыг зохион байгууллаа. Хурлыг аймгийн Засаг даргын орлогч В.Мөнхбат удирдан явуулж цаг үеийн мэдээ мэдээллийг танилцуулж, асуулт хариулт, санал хүсэлтийг сонсож сумдын дарга нарт сумдаас ирсэн зарим хүсэлтийг холбогдох мэргэжлийн байгууллагуудад уламжилж эргэж албан бичгээр хариуг мэдэгдэхийг холбогдох байгууллагуудад Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн ERP системд байгууллагын албан хаагчдыг бүрэн нэвтрүүлэх, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 02 сарын 19-ний өдрийн 03/227 тоот албан бичгийн дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах, Зарим сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар солигдсонтой холбоотойгоор Цэргийн штабт хамааралтай нууц баримт бичгийг сайтар хүлээлцүүлэх, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, Цэргийн албаны тухай хууль Дайчилгааны тухай хууль, Орон нутгийн хамгаалалтын тухай хууль, эдгээр хуулиудыг даган гарсан журам, зааврыг судалж, үүрэгт ажилдаа мөрдлөг болгон ажиллах, биелэлтэд хяналт тавих зэрэг 13 төрлийн үүрэг даалгавар өглөө.

## **Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд**

### **Татвар төлөлт**

2021 оны 2-р сард хүлээгдэж буй гүйцэтгэлээр улсын төсөвт 114.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 116.0 сая төгрөг төвлөрүүлэхээр, аймгийн төсөвт 642.4 сая төгрөг төвлөрүүлэхээс 646.5 сая төгрөг төвлөрүүлэхээр ажиллаж байна.

Цахимаар татвар төлөх талаар видео бичлэг, татварын тайлан хүргүүлэх хугацааг сануулсан, татвар хууль тогтоомжтой холбоотой 15 мэдээ, мэдээллийг Архангай аймгийн Татварын хэлтсийн пэйж хуудсанд 2-3 удаагийн давтамжтайгаар байршуулан, 780 хүн үзэж, 317 хүн шейр хийж, бусдад түгээсэн.

### **Хөрөнгө оруулалт**

2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 41.177.4 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 45 төсөл арга хэмжээ, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3.666.2 мянган төгрөгийн 28 төсөл, арга хэмжээ, авто замын сангийн хөрөнгөөр 315.0 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр тус тус батлагдсан байна.

### **Санхүүгийн хяналт**

2020 оноос шилжин төлөвлөгдсөн аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, Орон нутгийн өмчийн газарт хяналт шалгалт хийгдэж, шалгалтын дүнтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэх, тайлагнах шатандаа явж байна.

Аудитор, улсын байцаагч нарт урд онд тогтоогдсон нөхөн төлбөрийг барагдуулах, албан шаардлагаар өгсөн үүрэг, зөрчлийг арилгуулах ажлын явц байдлыг эрчимжүүлэх үүргийг удирдлагаас өгч үүний үр дүнд аймаг, сумдын төсөвт албан байгууллагуудтай нөхөн төлбөрийн тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулах ажил дууссан байна.

## **Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд**

### **Хууль, хяналт**

2021 оны 02 дугаар сард онцгой байдлын газарт гамшиг осол, аюулт үзэгдэл объектын гал түймрийн 5 дуудлага хүлээн авч ажилласан байна.

Онцгой байдлын газрын дарга, Эрдэнэбулган сумын Засаг дарга, Эрдэнэбулганы цахилгаан дамжуулах ТӨХК-ын дарга нарын хамтран баталсан удирдамжийн дагуу Эрдэнэбулган сумын 4, 5 дугаар багт байрлах гэр хороолол, худалдаа үйлчилгээний барилга байгууламжуудад Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль тогтоомж болон Гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 14 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 2-р сарын 11-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Шалгалтаар 16 хүнсний дэлгүүр, 3 авто засвар, үйлчилгээний төв, гэр хорооллын 254 айл өрх хамрагдаж Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, норм, стандартын холбогдох заалтыг зөрчсөн 126 зөрчил илрүүлж, 54 зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулан бусад зөрчлүүдийг арилгуулахаар гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 6, мэдэгдэл 8-ийг тус тус бичиж зөрчил дутагдлыг арилгууллаа.

Архангай аймгийн 19 сумын Засаг дарга болон тамгын газрын дарга нарт сум багийн ажилтнуудыг дайчлан алслагдсан гэр хороолол, отор нүүдлээр яваа айл өрхүүдэд хүрч ажиллах, цахилгааны аюулгүй байдал, пийшин зуухны галын аюулгүй байдлыг хангах талаар заавар зөвлөмжийг хүргэж, бага насны хүүхдийг харж асрах хүнгүй орхих, гэр орон сууцанд цоожлох зөрчил дутагдлыг илрүүлэх талаар гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага хүргүүлэн ажиллаа.

Цагаан сарын баярт зориулсан үзэсгэлэн худалдаа, зар сурталчилгаа, хөнгөлөлт, урамшуулал зарлахгүй байх олон хүн төвлөрүүлэхгүй байхыг бүх төрлийн худалдаа, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагад үүрэг болгосны дагуу 150 гаруй байгууллага, аж ахуйн нэгжид Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрдэнэбулган сумын хяналтын байцаагч нарын хамтарсан удирдамжит хяналт шалгалтыг зохион байгууллаа.

2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 10.50 цагт Халдварт өвчин судлалын үндэсний төв, аймгийн Тагнуулын хэлтсээс Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороонд ковид-19-ийн батлагдсан тохиолдолын ойрын хавьтал Архангай аймагт ирсэн мэдээллийн дагуу аймгийн Онцгой комиссын Шуурхай штабаас шуурхай хариу арга хэмжээ авч ажилласан.

Шуурхай хариу арга хэмжээний баг ойрын хавьтлын 3 том хүн, 1 хүүхэд, дам хавьтлын 3 том хүн, 2 хүүхэд нийт 9 хүнээс 2 удаа шинжилгээний сорьц авч, аймгийн Нэгдсэн эмнэлгийн лабораторит хүргүүлэн GeneXpert аппаратаар шинжилгээ хийж, бүгд сөрөг гарсан. Тусгаарлах байранд ойрын хавьтлын 4 хүнийг тусгаарласан ба аймагт ирснээс хойш явсан маршрутын зураглалыг гаргаж ЗӨСТ-ийн халдваргүйтгэлийн баг 2110 м.кв талбайд халдваргүйтгэл хийж шуурхай хариу арга хэмжээ авч ажилласан.

2021 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Улаанбаатар хотоос Завхан аймгийн чиглэлд зорчиж байсан нэг иргэн PCR шинжилгээний хариугаа хүлээлгүй нийслэлээс гарч, замдаа шинжилгээний хариу нь эерэг гарсан тухай мэдээллийн дагуу Архангай аймгийн Цагаан хаалганы хяналтын постонд саатуулж, батлагдсан тохиолдлыг халдвар хамгааллын дэглэмийн дор Улаанбаатар хот ХӨСҮТөв рүү хүргэх ажлыг зохион байгуулсан.

Архангай аймгийн Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч нар нь Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд хязгаарлалтын дэглэм, Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж аймгийн Засаг даргын захирамж, Онцгой комиссоос өгсөн заавар зөвлөмжийг зөрчсөн, зөвшөөрөл болон шинжилгээний бичиггүй хүн тээвэрлэсэн, гэрийн тусгаарлалтын 14 хоногийн хугацааг дуусгалгүй гадуур явсан зөрчил дутагдлыг илрүүлж нийт 11 ачаа тээврийн жолооч болон иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцож аймгийн прокурорын байгууллагад шилжүүлээд байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар Улаанбаатар хотод хөл хорионд орсон иргэдээ татан авах ажлын хэсгийг байгуулж 2021.02.05-наас Улаанбаатар хот болон бусад аймгаас Архангай аймагт ирсэн иргэдийн бүртгэлийг цахим хэлбэрт /GOOGLE FORM/ шилжүүлэн 19 сумын Онцгой комисст бүртгэлийг хэрхэн хийх тухай заавар өгч ажилласан.

Нийтийн тээврийн тусгай үүргийн 19 автобусаар 635 иргэн, 525 хувийн тээврийн хэрэгслээр 1162 иргэн нийт 1797 хүнийг татан авч гэрийн ажиглалтад авсан байна. Татан авалтаар ирсэн иргэдийг хяналтын постоор PCR шинжилгээний хариуг үндэслэн мөн аймгийн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авч нэвтрүүлсэн байна.

Шинэ Коронавируст Covid-19 цар халдвараас урьдчилан сэргийлэх, цаг үеийн мэдээ мэдээлэл, заавар зөвлөмж, цаг үеийн мэдээг өдөрт 2-4 удаагийн давтамжтайгаар олон нийтэд мэдээлж Онцгой байдлын газрын пэйж хуудсанд дээрх мэдээ сурвалжлагыг байрлуулж 13.204 иргэнд хүрч хандалт авсан байна.

Баяр амралтын өдрүүдэд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа томоохон худалдааны төв “Гост”, “Тансаг”, “Тэрх”, “Хасу” нийтийн худалдааны төвийн ажилчид, үйлчлүүлэгчид, ард иргэдэд гал түймэр, гамшиг осол, коронавирус /ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, хот хоорондын нийтийн тээврийн хөдөлгөөнийг түр зогсоосонтой холбогдуулан иргэд, жолооч нарт баталгаагүй замаар, гол нуурын мөсөн дээгүүр зорчихгүй байх анхааруулга мэдээ мэдээллийг автомашин болон худалдааны төвийн чанга яригч, орон нутгийн “АВ”, Тамир телевизээр 8 удаагийн давтамжтайгаар 240 минутын сэрэмжлүүлэг шторк, 1 удаагийн ярилцлага хүргэж Онцгой байдлын газрын facebook болон [www.ar.nema.gov.mn](http://www.ar.nema.gov.mn) вэб сайт болон чанга яригчтай тусгай зориулалтын 3 автомашинаар 4 өдөр зарлан мэдээллийг иргэдэд хүргэсэн.

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх 3, цаг үеийн мэдээ мэдээлэл 2 төрлийн шторкыг “АВ” телевизээр өдөрт 10 удаагийн давтамжтайгаар нийт 100 минут нэвтрүүлж урьдчилан сэргийлэх чиглэлээр 5196 иргэнд ухуулга сурталчилгаа хийж 750 санамж боршур тарааж ажиллалаа.

“АВ” телевиз, “Тамир” телевиз цаг үеийн холбогдолтой тодруулга буланд 9 удаагийн ярилцлага өгч “Архангайн амьдрал сонинд 6 удаа мэдээ нийтлүүлсэн. Аймгийн ард иргэдийг бодит үнэн зөв мэдээллээр хангах зорилгоор Улсын Онцгой комисс, Эрүүл мэндийн яам, Онцгой байдлын ерөнхий газрын вэб сайтаас мэдээг авч олон нийтийн хэрэгслээр түгээж байна.

Засгийн газрын 2021 оны 02 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/80 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Цагдаагийн газар, Эрдэнэбулган сумын Засаг даргын Тамгын газартай хамтран 28 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй 12 ажлын хэсэг Эрдэнэбулган сумын зургаан багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 98 хүнсний худалдаа, 23 нийтийн хоолны газарт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар нийт 25326 ширхэг пиво, 11151 ширхэг вино, 149357 ширхэг архи согтууруулах ундааг тоолж битүүмжиллээ.

Мөн худалдаа үйлчилгээний байгууллагын цэвэрлэгээ үйлчилгээ, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах ажлын хүрээнд Эрдэнэбулган сумын 13 хүнсний худалдаа, үйлчилгээний дэлгүүрийн 1072 м квадрат талбайд “Дондог боржигон”, “Мэргэн насан” ХХК-аар халдваргүйтгэл хийлгэхэд хяналт тавин ажиллалаа. 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс 2021 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн хооронд УБ хотоос хувийн тээврийн хэрэгслээр ирсэн 112 иргэн, нийтийн тээврийн хэрэгслээр ирсэн 241 иргэний түргэвчилсэн шинжилгээнд хамрагдаж буй байдал, түргэвчилсэн шинжилгээ авах түр цэгийн халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлт болон авто тээврийн төвийн кассын хэсэг, 11 автобусны 237 м квадрат талбайд аймгийн ЗӨСТ-ийн хийсэн халдваргүйжүүлэлтэнд хяналт тавин ажиллалаа.

2021 оны 1-р сард аймгийн хэмжээнд 22 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 7, малын хулгайн гэмт хэрэг 3, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 1, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 5, гэмт хэргийн илрүүлэлт 0.0 хувьтай байна.

Нийт 1444 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 1356 иргэнд 50236.1 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 26.6 сая төгрөг, нөхөн төлүүлэлтийн хувь 13.2 хувьтай байна.

Стандарт, хэмжил зүйн хэлтэст бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын чиглэлээр Эрдэнэмандал, Цэнхэр, Ихтамир, Булган, Эрдэнэбулган, Булган, Өлзийт сумдаас Тохирлын гэрчилгээ сунгуулах болон шинээр авахаар ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэн 5 ААН, 17 иргэний үйлчилгээнд тохирлын үнэлгээ хийж ажилласан байна.

Улсын бүртгэлийн хэлтэс 2-р сард дараах бүртгэлийг хийсэн байна.

#### **Иргэний бүртгэл чиглэлээр:**

- Төрсний бүртгэл – 161
- Гэрлэсний бүртгэл - 143

- Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл -6
- Эцэг тогтоосны бүртгэл - 10
- Үрчилсний бүртгэл - 5
- Овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл - 5
- Нас барсны бүртгэл - 43
- Шинээр иргэний үнэмлэх олгосны бүртгэл - 133
- Дахин олгосон – 71
- Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 226 бүртгэл хийгдсэн байна.

#### **Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:**

2021 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар иргэн хуулийн этгээдээс нийт 353 мэдүүлгийг хүлээн авч дараах бүртгэлийн хийж гүйцэтгэлээ.

- Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл – 23
- Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 28
- Шинээр бүртгүүлсэн орон сууцны бүртгэл -5
- Газар эзэмших эрхийн анхны бүртгэл –285
- Арилжааны гэрээ – 0
- Худалдах худалдан авах гэрээ – 53
- Бэлэглэлийн гэрээ – 7
- Барьцааны эрхийн бүртгэл – 196
- Өв залгамжлал – 0
- Хамтран өмчлөгч өөрчлөгдөх – 5
- Лавлагаа – 3
- Бусад эрхийн бүртгэл – 13

Хууль хяналтын байгууллагад нийт 42 лавлагааг гарган хүргүүлсэн байна. Дээрх бүртгэлүүдийг хийж улсын төсөвт үйлчилгээний хөлс 2.591.876 тэмдэгтийн хураамжид 133.172төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдсанаас оруулсан татварын орлого 10.851.348 төгрөг төвлөрүүлсэн байна

#### **Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:**

- Шинээр бүртгүүлсэн – 12
- Өөрчлөлт – 42
- Тамганы хяналтын дугаар олгосон – 14 бүртгэл хийсэн.

#### **Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд Боловсрол**

БШУЯ, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Боловсролын хүрээлэн хамтран ерөнхий боловсролын сургуулийн сурагч, сургуулийн өмнөх боловсролын хүмүүжигч хүүхдүүдэд теле хичээлийг тогтмол зохион байгуулан явуулж байна.

Үндсэн мэргэжлээрээ 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж байгаа ЕБС, хүүхдийн цэцэрлэгийн багш нарын Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт цахимаар зохион байгуулагдаж байна. Уг сургалтын жил бүр Багшийн мэргэжил дээшлүүлэх институтээс зохион байгуулдаг бөгөөд Архангай аймгаас энэ хичээлийн жилд 264 багш хамрагдаж, мэргэжил боловсролоо дээшлүүлж байна. 10 дахь жилдээ ажиллаж буй багш нарын сургалт 01 сарын 15-наас 03 сарын 01, 5 дахь жилийн багш нарын сургалт 3 сарын 2-ноос 3 сарын 23, эхний жилийн багш нарын сургалт 4 сарын 15-наас 5 сарын 28-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулагдах бөгөөд сургалтаар мэдсэн зүйлсээ ажлын байран дээр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зөвлөн туслах ажлыг БМДИ-ээс 9 сарын 15-наас 11 сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулан явуулна.

Энэ хичээлийн жилийн элсэлтийн ерөнхий шалгалтын бүртгэл 2 сарын 25-ны өдрөөс цахимаар зохион байгуулагдаж эхэлнэ. Элсэлтийн ерөнхий шалгалтыг Боловсролын үнэлгээний төв, аймгийн Боловсрол, соёл урлагийн газар хамтран зохион байгуулна. Энэ хичээлийн жилд өдрийн сургалтаар 1048, дүйцсэн хөтөлбөрөөр 55 төгсөгч 12-р ангиа төгсөнө.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/25 дугаар захирамжийн хүрээнд Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын 5 сургуульд урьдчилан сэргийлэх шалгалт хийж, улсын байцаагчийн 12 заалт бүхий зөвлөмжийг 20 сургуульд хүргүүлэн, биелэлтийг хөдөө орон нутгийн сургуулийн дотоод хяналтын ажилтнаар дамжуулан 14 хоног тутам тайланг хүлээн авч мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. 2021 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 12 ерөнхий боловсролын сургууль 12 дугаар ангийн сурагчдын давтлагыг эхлүүлсэн, 02 дугаар сарын 23-ны өдрөөс үлдсэн 8 ЕБС давталгаа эхлүүлэхээр бэлэн байдлаа хангаад байна.

Шалгалтаар 15 сургуулийн хичээлийн байрны 4484.1м<sup>2</sup> талбайд мэргэжлийн байгууллагаар халдваргүйтгэл хийлгүүлсэн, 12 дугаар ангийн сурагчдын давтлагад хамрагдалт 77%-тай, нийт багш ажилчдын 27%-ийг ажлын байранд давтлага зохион байгуулахаар ажиллуулсан байна. ЕБС-ын удирдлагуудад өгсөн зөвлөмжийн хүрээнд мэргэжлийн байгууллагаар халдваргүйтгэлийг 14 хоног тутам сургалтын байранд хийлгэж, багш, сурагчдын халуун хэмжиж, бүртгэл хөтөлсөн, 1 ангид дээд тал нь 10 сурагч 1.5-2м-ийн зайтай суухаар зохион байгуулсан зэрэг халдвар хамгааллын дэглэмийг сахиж үйл ажиллагаа явуулж байна.

### **Эрүүл мэнд**

Аймгийн хэмжээнд 2021 оны 1 дүгээр сард нийт 27964 үзлэг хийгдсэнээс бодит тоогоор 9512 буюу 34 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг эзэлж байна.

Хүн амын нас баралтын 30 тохиолдол бүртгэгдсэн. Нас баралтын шалтгаанд цусны эрхтэн тогтолцооны өвчлөлийн нас баралт 9, хорт хавдарын нас баралт 8, осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 11 тохиолдлоор тэргүүлж байна.

Өмнөх онтой харьцуулахад нийт нас баралт 62 тохиолдлоор, цусны эрхтэн тогтолцооны нас баралт 17 тохиолдлоор буурсан байна. 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл аймгийн хэмжээнд гараагүй байна.

Аймгийн хэмжээнд 2021 оны 1 сард халдварт өвчний нийт 22 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 4 тохиолдлоор буурсан. Цочмог халдварт өвчин 4 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 12 тохиолдлоор буурсан. Архаг халдвар өвчин 18 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 10 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Томуу томуу төст өвчний хөдлөл зүйгээс харахад сүүлийн 7 хоногийн хугацаанд амбулаторийн үзлэгт ТТӨ-ний тохиолдол 1.3% ба өмнөх 7 хоногтой харьцуулахад өвчлөл 0.7%-иар буурсан байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн түргэн тусламжийн дуудлагын 1.9%-ийг ТТӨ-ний шалтгаант дуудлага эзэлж, өмнөх 7 хоногоос 0.5%-иар буурсан. Эрдэнэбулган сумын Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд ТТӨ –ний өвчлөл амбулаторийн үзлэгт 1.4% байгаа нь өмнөх долоо хоногоос 0.2% -иар өссөн.

Ковид 19 цах тахлын дархлаажуулалтын төлөвлөлт, судалгаа бүх нэгжүүдэд хийгдсэн, одоо байгаа хүйтэн хэлхээг ашиглах бэлтгэл хангасан бөгөөд вакцинжуулалтын талаарх эмнэлгийн мэргэжилтний сургалт хийгдэж, вакцины хуваарийг хүлээж байна.

### **Соёл урлаг**

Улс орон даяар “Covid-19” цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлж, Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан аймгийн Нийтийн номын сан танхимын уншлага-үйлчилгээг тодорхой хязгаарлалттай зохион байгуулж нийтийн уншлагын танхимаар 37 уншигч, 50 ирэгсэдэд, 60 номоор, гэрээр ном олгох нийтийн уншлагын танхимаар 70 ирэгсэдэд, 90 ширхэг ном, 75 ирэгсэдэд 130 ширхэг тогтмол хэвлэл, хүүхдийн уншлагын танхимаар 7 уншигч, 10 ирэгсэдэд 17 ном олгож, аймгийн Ахмадын хороо, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, “Булган” МСҮТ зэрэг 3 байгууллагатай зөөврийн номын сангийн үйлчилгээний гэрээ байгуулж, 75 уншигч, 80 ном олгож тус тус үйлчилсэн байна.

Хөгжимт драмын театр, “АВ” телевизтэй хамтран бүтээсэн шинэ уран бүтээлийн “Сар шинийн мэнд” контент нэвтрүүлгийг бүтээж сар шинийн өдрүүдэд үзэгчдэд хүргэсэн.

Сар шинийн баярыг тохиолдуулан “АВ” телевизтэй хамтран өв соёлыг онцлох “Дээлтэй яриа” нэвтрүүлэгт аймгийн Музейн захирал, бүртгэл мэдээллийн санч нар оролцлоо.

### **Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал**

2021 оны 2 сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхитэй хайгч 1320 иргэн бүртгэлтэй байгаагаас 625 эмэгтэй. Шинэ ажлын байр 21 үүнээс байнгын ажлын байр 16, улирлын ажлын байр 4, түр ажлын байр 1 байна. Ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 42, зуучлал 35 байна. Тухайн сарын 18-ны байдлаар 168 иргэн нь шинээр бүртгүүлж, LMIS программд шивж оруулсан. Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилвал: боловсролгүй- 10, бага- 81, суурь-218, бүрэн дунд- 762, техникийн болон мэргэжлийн анхан шатны – 26, тусгай мэргэжлийн дунд-29, Дипломын бакалаврын-194 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна. Тухайн сард ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн 24 иргэнийг LMIS програмд шивж оруулан тодорхойлолт гарган өгч НДХэлтэс рүү хүргүүлсэн.

Нийгмийн даатгалын санд 2021 оны 01 дүгээр сарын 31-ны байдлаар нийт 4433.7 сая төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 100 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 14.9 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 5.7 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 518,3 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлжээ.

Нийгмийн даатгалын санд 2020 онд 1741,03 сая төгрөгийн сангийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.7 сая төгрөгөөр өсчээ.

Ажил олгогч, даатгуулагчаас төлсөн шимтгэлийн орлогыг дараах байдлаар нийгмийн даатгалын сангуудад хуваарилсан байна. Үүнд  
Тэтгэврийн даатгалын санд 89.4% буюу 3952.7 сая төгрөг  
Тэтгэмжийн даатгалын санд 2.6 % буюу 117.2 сая төгрөг;  
ҮОМШӨ-ний даатгалын санд 1.3% буюу 61.2 сая төгрөг;  
Ажилгүйдлийн даатгалын санд 0.8% буюу 39.5 сая төгрөг;  
Эрүүл мэндийн даатгалын санд 5.9% буюу 263.0 сая төгрөг

2021оны нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд нийт 5,7 тэрбум төгрөг зарцуулжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн зардал 0,7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

### **Гэр бүл, хүүхэд, залуучууд**

Хамтарсан багийг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай Аймгийн засаг даргын 2 дугаар сарын 04-ний өдрийн а/77 тоот захирамжийн хүрээнд Хамтарсан багийн гишүүдийн хурлыг зохион байгуулж, зөвлөлийн гишүүдийн чиг үүргийг тодорхойлж, сумын хамтарсан багуудад үйл ажиллагааг сайжруулах чиглэл хүргүүлсэн.

Гал түймрийн аюулд өртсөн 3 сумын 5 өрхөд хүнс, эд материалын дэмжлэг, Зорилтот бүлгийн 30 гэр бүл, хүүхдэд хүнсний дэмжлэг үзүүлэн ажилласан. Үйл ажиллагааны үр дүнд зорилтот гэр бүлүүдэд шаардлагатай тусламж, нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлсэн.

Хүүхдийн тусламжийн утас 108-д ирсэн 2 дуудлага мэдээллийг Эрдэнэбулган, Жаргалант суманд тус тус шилжүүлж хамтарсан багийг хүүхдийн гэр бүлийн асуудалд үнэлгээ хийж, төлөвлөгөө гарган ажиллахад арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Аймгийн Засаг даргын 2021 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн А/75 дугаар захирамжаар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх аймгийн дэд хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг 17 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, дэд ажлын хэсгүүдийг томилж дэд хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулахтай холбогдуулан Гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн байдлын талаарх тоон мэдээлэл, дэд хөтөлбөр боловсруулах хууль эрх зүйн орчинд тавигдаж буй шаардлагын талаар арга зүйн дэмжлэг үзүүлэх уулзалтыг зохион байгуулж, санал хүсэлтийг сонсож ажилласан. Гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх зорилгоор ЦГ, ХХҮГ, ЭМГ, Шүүх тамгын газар, Прокурорын газар, Шүүх шинжилгээний алба зэрэг байгууллагаас гэр бүлийн

хүчирхийлэлтэй холбогдох сүүлийн 3 жилийн мэдээ тайлан авах ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн 05/212 тоот бичгийг хүргүүлсэн. Мөн иргэдийн ойлголт хандлагыг тодруулах, дэд хөтөлбөр боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох асуулга, ярилцлагын асуумж, удирдамжийг боловсруулан судалгааг цахим болон цаасан хэлбэрээр авч байна.

### **Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд Мал аж ахуй**

Аймгийн хэмжээнд энэ онд 5399530 толгой мал өвөлжиж байна. Архангай аймагт 5 аймгийн 40-д сумаас 303 өрхийн 200 орчим мянган толгой мал отроор өвөлжиж байна. Үүнээс Улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 3 сумын 709 малчин өрхийн 73.2 мянган толгой мал, аймаг, орон нутгийн тусгай хэрэгцээний нөөц нутагт 2 сумын 71 малчин өрхийн 31.5 мянган толгой мал, Дорнод, Сүхбаатар, Төв, Булган, Хэнтий аймаг, Улаанбаатар хотын Гачуурт, 61-н гарамд 104 малчин өрхийн 44,9 мянган толгой мал отроор өвөлжиж байна. Баянхонгор аймгийн 19 сумаас манай аймгийн 13 суманд 169 өрхийн 59.7 мянган толгой мал, Өвөрхангай аймгаас манай аймгийн 12 суманд 91 өрхийн 38 мянган толгой мал, Завхан, Хөвсгөл, Булган аймгуудын нутгаас 43 малчин өрхийн 15.7 мянган толгой мал үүнээс манай аймгийн зарим сумдын нутагт отроор өвөлжиж байна. Бусад малчдын хувьд сум орон нутагтаа отор нүүдэл хийн өвөлжиж байна.

Малчид өөрийн аймгийн болон Төв, Сэлэнгэ, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Увс зэрэг аймгуудын нутгаас малчдын түвшинд 51.4 мянган тн өвс, 8317 тн ногоон тэжээл, 1009 тн гар тэжээл, 12 тн үйлдвэрийн тэжээл, 579.6 тн давс хужир шүүг нөөцлөн авсан. Тэжээл бэлтгэл 66 орчим хувь байсанаас 11 сарын дундаас мал нэмэгдэл тэжээлд орсон. Нийт тэжээлийн 80 гаран хувийг малчид малдаа хэрэглэсэн байна. Сумдын нөөц бүрдүүлэлт өвс 1328 тн, тэжээл 261 тн байснаас 50-60 хувийг малчдадаа зарж борлуулсан. Одоогоор сумдын нөөцөд 562 тн өвс, 173 тн тэжээл байна. Энэ онд Засгийн газрын 19 дүгээр тогтоолын дагуу аймгийн аюулгүй нөөцөд 325 тн өвс нөөцөлснөөс нөөцөд 80 орчим тн өвс байна. 2021 оны 01 дүгээр сарын 01-13-ны байдлаар 14 суманд бод 3993, бог 11493 толгой буюу нийт 15486 толгой мал хорогдсон байна.

Нэгдсэн үндэсний байгууллагын Хөдөө аж ахуйн байгууллага Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран хэрэгжүүлж буй Зорилтот бүлгийн малчин өрхийн амьжиргааг зудын эрсдэлээс хамгаалахад дэмжлэг үзүүлэх техник туслалцааны төслийн хүрээнд Батцэнгэл, Өгийнуур, Өлзийт, Хайрхан, Эрдэнэмандал, Хотонт, Хашаат сумдын зорилтот бүлгийн хонин толгойд шилжүүлснээр 60-300 малтай, өрх толгойлсон, олон хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнтэй нийт 112 өрхөд /нэг сумын 16 өрх/ тусламж дэмжлэг үзүүлэх ажлыг 1-р сарын 16-20-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тусламжийн багцад хорголжин тэжээл, рапсын шахдас, "Амин тун", "Барагшуунт" сувиллын бэлдмэл, шархны тос, нүдний тос, хурганы уут, малчдад өгөх зөвлөмж, 5000 төгрөгийн нэгж багтсан байна.

XVII жарны "Цөөвөр" хэмээх цагагчин үхэр жилийн босгон дээр Монгол Улсын Засгийн газраас Улсын аварга малчдыг тодруулсан. Энэ жил Архангай аймгаас "Улсын хошой аварга малчин" 1, "Улсын аварга саальчин" 1, "Улсын аварга малчин" 10, нийт 12 аварга малчинтай болсон байна.

### **Газар тариалан**

Үр тарианы аж ахуй эрхэлдэг 49 иргэн, аж ахуйн нэгжийн 12979 га-д тариалах 2161 тн үрийн захиалга авч Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.

### **Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд**

#### **Хүнс, үйлдвэрлэл, үйлчилгээ**

2021 оны 02 сарын 24-ний байдлаар хүнсний нөөцийн судалгаа мах 179.5 тн буюу 14 хоног, гурил 243.5 тн буюу 34 хоног, гоймон 35.7 тн буюу 3 хоног, будаа 78.6



тн буюу 18 хоног, сахар 47.2 тн буюу 19 хоног, ургамлын тос 13.5 тн буюу 8 хоног, давс 23.1 тн буюу 57 хоног, ундны ус 23.8 мян.л буюу 1 хоног, хуурай сүү 5.1 тн буюу 4 хоног, төмс 68 тн буюу 23 хоног, хүнсний ногоо 12.2 тн буюу 1 хоног, өндөг 0.7 тн буюу 11 хоногийн нөөцтэй байна.

Зам, тээврийн хөгжлийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан А/225, А/379 тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж, [www.teeverzuuch.mn](http://www.teeverzuuch.mn) сайтад хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, өвс тэжээлийн захиалга үүсгэж байна. 02 дугаар сарын 24-ний байдлаар 748 тээвэрлэлтэнд захиалга үүсгэсэн байна.

Аймгийн хэмжээнд модон эдлэлийн - 52, оёмол бүтээгдэхүүний - 43, барилгын материалын - 28, арьс шир эдлэх - 25, эсгий, ноос боловсруулах - 17, бусад - 56 нийт 221 жижиг үйлдвэр, цех үйл ажиллагаа явуулж 399 иргэнийг ажлын байраар ханган ажиллаж байна.

### **Барилга, дэд бүтэц**

Барилгын материалын лабораторийн үйл ажиллагааг итгэмжлэх ажлын хүрээнд Стандарт Хэмжилзүйн газраас итгэмжлэлийн цахим хурлыг 2021 оны 1 сарын 25-нд зохион байгуулж Итгэмжлэлийн хорооны хурлаар ГХБХБГ-ын барилгын материалын лаборатори нь гишүүдийн 100%-ийн саналаар дэмжигдэн 4 жилийн хугацаагаар итгэмжлэгдлээ.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжих ТЭЗҮ боловсруулах ажлын жагсаалтын гарган аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэн батлуулсан. Үүнд:

- Ерөнхий төлөвлөгөөний зургийн даалгавар – 4
- Барилга угсралтын ажлын зургийн даалгавар – 13
- Их засварын ажлын зургийн даалгавар – 6
- Тохижилтын ажлын зургийн даалгавар – 1

Газрын төлбөр, татварын цахим системд газрын төлбөрийг бодуулан 2021 оны ногдуулалтыг үүсгэж төлбөрийн нэхэмлэлийг татварын дундын мэдээлийн санд аймгийн хэмжээний 1367 иргэн, аж ахуйн нэгж байгуулагад 13, Орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр 80.0 сая төгрөгийн төлөвлөгөөтөйгөөс 144,09 сая төгрөгийн нэхэмжлэлийг үүсгэж татварын дундын мэдээллийн санд илгээсэн

Газар эзэмших эрхийн дуудлага худалдаагаар эзэмшүүлэхээр төлөвлөгөөнд тусгагдсан байршилд 6 сумын 17 байршилд 231.58 га талбайд дуудлага худалдааны анхны үнээр 96.8 сая төгрөгийн дуудлага худалдааг зохион байгуулахаар газрын биржийн цахим системд оруулж баталгаажуулсан.

Хаягжуулалтын тухай хуулийн дагуу аймгийн 19 сумын иргэн, аж ахуйн нэгж байгууллын, эзэмшил өмчлөл, ашиглалтын газрыг 420 нэгж талбар, 185 гудамжыг шинэчилэн тодорхойлж хаягийн мэдээллийн системд оруулсан

### **Долоо. Сум, орон нутгийн мэдээлэл**

#### **Жаргалант сум**

Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл анхдугаар хуралдаанаа хийж 2021 оны ажлын төлөвлөгөөгөө батлаж, шинээр батлагдсан Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулав.

#### **Өндөр-Улаан сум**

2021 оны 2-р сарын 08-ны өдөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуралдаж сумын Засаг даргын 2021-2024 онд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг 4 бодлогын хүрээнд 17 салбар чиглэлийн 148 арга хэмжээтэйгээр баталсан байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

-----oOo-----